



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВ

Энхтайваны өргөн чөлөө 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 31 17 33, Факс: (976-11) 31 38 20,
Цахим хуудас: www.pathology-center.gov.mn


2024.12.16 № 424
танай 2024.12.02-ны № 8/5020-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗАРТ

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.3 дахь хэсэгт заасны дагуу 3.5, 3.6, 3.7 дугаар хүснэгтийн дагуу Эмгэг судлалын үндэсний төвийн 2024 оны тайланг хавсралтаар илгээв.

Хавсралт ... хуудастай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ *Б.Ганзориг* Б.ГАНЗОРИГ



D:\2024\Alban bichig A5.docx
14210253

ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ



2024.12.16

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа I-IV улирал/	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл ийн хувь
<u>Стратегийн зорилго 1.</u> 2.2.11 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.								
Стратегийн зорилт 01. Эрүүл мэндийн сайдаас тусгайлан өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх								
1.1.	Эмгэг судлалын үндэсний төвийн 2024-2027 онд хэрэгжүүлэх "Стратеги төлөвлөгөө"-г боловсруулж батлуулна.	-	- Батлагдсан стратеги төлөвлөгөө: - 2024 онд төлөвлөсөн ажлын хэрэгжилтийн хувь	2022-2025 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулсан ЭМСайдын тушаалаар батлуулаагүй.	Стратеги төлөвлөгөө батлагдаж, 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	I-IV улирал	Эмгэг судлалын үндэсний төвийн 2024-2027 оны стратеги төлөвлөгөөг удирдлагын зөвлөлийн хурлаар 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр хэлэлцүүлж төсөл боловсруулсан.	50%
1.2.	Эмгэг судлалын дүрэм, бүтцийг шинэчлэн батлуулна.	-	Батлагдсан тушаал	"Эмгэг судлалын үндэсний төвийн дүрэм, бүтцийн тушаалыг шинэчлэн батлуулахаар ЭМЯ-нд хүргүүлсэн.	Шинэчлэн батлуулсан дүрэм бүтцийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.	I-II улирал	1. ЭМЯ-ны дэргэдэх Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн 2024.07.31-ний өдрийн хурлаар ЭСҮТ-ийн дүрэм, бүтцийн төслийг шинэчлэн боловсруулсан. 2. Мөн тушаалын төсөл болон "Арга хэмжээний төлөвлөгөө"-г хэлэлцүүлсэн. 3. Удирдлагын зөвлөлийн хурлаар 2024.08.01-ний өдөр ЭСҮТ-ийн дүрэм бүтцийг шинэчлэн батлуулах тушаалын төсөл хэлэлцүүлсэн. 4. Аймаг, орон нутагт ажиллаж байгаа тасаг нэгжүүдтэй цахим хурал зохион байгуулж, холбогдох саналыг тусгасан. 5. Тус төвийн дүрэм бүтцийг ЭМС-н өгсөн үүргийн дагуу боловсруулан удирдлагын зөвлөлөөр	70%

							хэлэлцүүлэн ЭМЯ-нд 2024.08.12-ны №263 дугаар албан бичгээр, хавсралтаар хүргүүлсэн.	
1.3.	Тус төвийн хүний нөөцийн 2024-2027 оны хөгжил, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулна.	-	Шинэчлэн боловсруулсан хөтөлбөр	2021 онд боловсруулан баталсан хөтөлбөрийн хугацаа дууссан.	Шинээр батлагдсан хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.	I-II улирал	Төвийн 2024-2027 онд хэрэгжүүлэх Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд: - БНХАУ-д мэргэжил дээшлүүлэх сургалтад 1 сарын сургалтад 4 эмч, мэргэжилтнүүдийг хамруулж, цалинтай чөлөө олгосон. - БНСУ, Австри улс, Япон улсад зохион байгуулагдсан олон улсын хуралд нийт 4 эмгэг судлаач эмч, 1 резидент эмч хамрагдсан бөгөөд цалинтай чөлөөг олгож байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлсэн. - АНУ-ын Харвард АУ-ы сургуулийн улсын "Анагаах ухааны манлайлал" мэргэжил дээшлүүлэх тэтгэлэгт хөтөлбөрт 1 мэргэжилтэн шалгарч эхний семинарт хамрагдахад цалинтай чөлөөг олгосон. - Ажиллангаа суралцаж байгаа ажилтнуудад (докторын хөтөлбөрт-5, магистрын хөтөлбөрт-9) дэмжлэг үзүүлэх зорилгоор хамтын ажиллагааны гэрээ байгуулсан сургуульд суралцаж байвал төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, мөн ажлын цагийн зохицуулалтыг хийдэг. - Байгууллагын нийт ажилтнуудын нийгмийн баталгааг хангах зорилгоор улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал болон жилийн эцсийн ажлын үр дүнг мөнгөн урамшуулалд нийт давхардсан тоогоор 265 ажилтанд 192,6 сая төгрөгийг олгосон. Мөн ажилтнуудад хоол, унааны	100%

							хөнгөлөтөд, хор саармагжуулах бүтээгдээнд 97,6 сая төгрөгийг зарцуулсан. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 3 ажилтанд 59,4 сая төгрөг, 1 удаагийн тэтгэмж, шагналын дагалдах мөнгөнд 2,5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. - Байгууллагын нийт ажилтнуудын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хугацаат үзлэгийг 2024.11.14-15-ны өдрүүдэд УНТЭ-ийн “Эрүүл мэндийг дэмжих төв”-тэй хамтран зохион байгуулсан. - Байгууллагын нийт ажилтнуудын хөдөлмөрлөх боломжийг хангах зорилгоор ажлын дүрэмт хувцасыг иж бүрдлээр нь олгосон.	
1.4.	Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний түгээмэл үйлдлийн MNS 7015:2023 стандартын дагуу “Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний Эмнэлзүйн заавар” боловсруулна.	-	Батлагдсан тушаал	2023 онд MNS 7015:2023 стандартыг боловсруулан батлуулсан.	Эмнэлзүйн зааврыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулна.	I-III улирал	MNS 7015:2023 Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний түгээмэл үйлдэл, ЭМСайдын 2023 оны А/447 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” (“Эмгэг судлалын шинжилгээ хийх журам”, “Амьд сорьцын эмгэг эд, эс судлалын шинжилгээ хийх журам”) шинэчлэгдсэнтэй холбоотойгоор тус үндэсний төвийн үйл ажиллагаанд нийцүүлэн ЭСҮТ-ийн захирлын 2024.12.09-ний өдрийн А/60 дугаар тушаалаар “Журам батлах тухай” (Эмгэг судлалын шинжилгээний журам, амьд сорьцын шинжилгээний журмуудыг) батлуулсан. Үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	100%
1.5.	Эмгэг судлалын тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтэд хамруулахад шаардлагатай	-	- Судалгааны тайлан Шийдвэрийн төсөл	Эмгэг судлалын өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээний төлбөрийг иргэн өөрөө хариуцаж байна.	- Өртөг тооцох болон Хууль эрх зүйн орчны судалгаа хийгдэж шийдвэр гаргах түвшинд	I-IV улирал	- ЭМДҮЗ-ийн 2024 оны 6-р тогтоолын 4-р хавсралтын 2.2.2-т “Эмгэг судлалын шинжилгээг ЭМД-ын сангаас санхүүжүүлэхдээ Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчит ЭМБ-аас үзүүлэх нэмэлт болон	100%

	судалгааг хийж, шийдвэр гаргах түвшинд танилцуулна.				танилцуулсан байна.		төлбөртэй ТҮ-ний төлбөрийн жишиг хэмжээг баримтална. ЭМДЕГ-ын даргын тушаалаар жагсаалтыг батална." гэж тусгагдсан. Үүний дагуу ЭМДЕГ-ын даргын тушаал боловсруулагдаж санал авах шатандаа явагдаж байна. - Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт"-д шинээр нэмэхээр Молекул патологийн шинжилгээний 3 нэр төрөл болон өмнөх жагсаалтын нэр төрлийг нарийвчлан задлах шаардлагатай байгаа тул саналаа 2024.10.25-ны өдөр 355 дугаартай албан бичгээр ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн бодлогын газарт хүргүүлсэн. - Мөн 2024.11.08-ны өдөр 377 дугаартай албан бичгээр ЭМЯ-ны Санхүү, даатгалын хэлтэст Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49/А/118 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт"-д оруулах саналаа өгсөн. - Дээрх 2 тушаалын төсөлд эмгэг судлалын тусламж, үйлчилгээний 5 нэр төрлийг нарийвчлан задалж 27 болгосон ба шинжилгээ тус бүрээр өртөгийг тооцож төлбөрийн жишиг хэмжээний саналаа хүргүүлсэн болно. - Гэрээ байгуулж хамтран ажиллах, нэхэмжлэлд тусгах шалгуурын	
--	---	--	--	--	---------------------	--	--	--

							талаар 2024.11.12-ны №383, 2024.11.22-ны №400, 2024.12.10-ны №419 тоотойр ЭМДЕГ-т албан бичиг илгээв.	
Стратегийн зорилго 2. Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлнэ.								
2.1.	Чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2015 стандартын баталгаажуулалтын байгууллагын магадлах аудитад хамрагдана.	15 сая.төг	MNS ISO 9001:2015 стандартын гэрчилгээ	2022 онд Анхан шатны хөндлөнгийн аудитад амжилттай хамрагдаж гэрчилгээ авсан болно.	MNS ISO 9001:2015 стандартын баталгаажуулалтын магадлах аудитад хамрагдсан байна.	I-IV улирал	2023 оны 12 дугаар сарын 15-ны магадлах аудитын тайланд тусгагдсан MNS ISO 9001:2016 стандартын 6.2 заалт “Чанарын зорилтууд ба төлөвлөлт”, 7.1.3 заалт “Дэд бүтэц”, 7.1.4 заалт “Үйл явцыг хэрэгжүүлэх орчин” гэсэн 3 сайжруулах саналын дагуу Чанарын удирдлагын тогтолцооны 2024 оны “Сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 1. 2021-2023 онд байгууллагын чанарын зорилтуудыг хангах чиглэлээр хийгдсэн үйл ажиллагааны хэрэгжилтийг гаргаж, 2024 оны 2-р сарын 5-ны өдрийн Удирдлагын дүн шинжилгээгээр Төвийн чанарын 6 зорилт, 15 дэд зорилтын биелэлтийг хэлэлцсэн. 2. Эмгэг Судлалын Лавлагаа лабораторийн үйл ажиллагааг удирдах, гүйцэтгэхэд шаардлагатай дэд бүтцийг сайжруулахаар төвийн өрөөнүүдийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн шинэчилсэн. MNS ISO 15189:2015 стандартын шаардлагад нийцүүлэн Лавлагаа лабораторийн байршлыг нүүлгэн шилжүүлсэн.	80%

								
2.2.	Эрүүл мэндийн лаборатори чанар ба чадавхад тавигдах шаардлага MNS ISO 15189:2015 стандартыг хэрэгжүүлэгч байгууллага	30 сая.төг	MNS ISO 15189:2015 стандартын хамрагдсан гэрчилгээ	Чанарын гарын авлага болон холбогдох стандарт үйл ажиллагааны журмууд, баримтжуулсан мэдээлэл, САЗ зэргийг боловсруулсан.	MNS ISO 15189:2015 стандартын баталгаажилтад хамрагдсан байна.	I-IV улирал	4. Чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2015 стандартын баталгаажуулалтын байгууллагын магадлах аудитадын хөндлөнгийн аудитад хамрагдах хүсэлтээ хүргүүлсэн ба 2024 оны 12-р сарын 25-ны өдөр аудитын баг ирэхээр төлөвлөсөн. 1. Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/110 тоот “Эмгэг судлалын тусламж үйлчилгээний баримт бичгийн багц боловсруулах баг томилох тухай” тушаалаар томилогдсон багийн гишүүд “Эрүүл мэндийн лаборатори чанар ба чадавхид тавигдах шаардлага” MNS ISO 15189:2022 стандартыг хэрэгжүүлэгч байгууллага	80%

	болж, итгэмжлэгдэнэ.						болж, итгэмжлэгдэхээр бэлтгэл үйл ажиллагааг ханган, төлөвлөгөө гарган ажиллаж байна. 2. Нийт 22 журам шинэчлэгдэн боловсруулагдсан.  3. Эрүүл мэндийн лаборатори чанар ба чадавхид тавигдах шаардлага MNS ISO 15189:2022 стандартын дотоод аудиторын сургалтанд 6 сарын 2-3-ны өдрүүдэд 3 мэргэжилтэн хамрагдаж, дотоод аудиторын гэрчилгээ гардан авсан. 4. MNS ISO 15189:2022 стандарт шинэчлэгдэж байгаатай холбоотой хүсэлт өгөх үйл явцыг хойшлуулж байсан ба 2024 оны 10-р сард MNS ISO 15189:2024 стандарт шинэчлэгдэж батлагдсан. Иймд Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага MNS ISO 15189:2024 стандартыг 2025 оны II улиралд хэрэгжүүлэгч байгууллага болж, итгэмжлэгдэхээр бэлтгэл үйл ажиллагааг ханган, төлөвлөгөө гарган ажиллаж байна. 5. Шинэчлэгдэж батлагдсан MNS ISO 15189:2024 Эрүүл мэндийн	
--	-------------------------	--	--	--	--	--	---	--

							лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага сэдэвт сургалтанд 1 мэргэжилтэн хамрагдсан.	
2.3.	Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлэгч байгууллага болно.	10 сая - Улсын төсөв	- Батлагдсан төлөвлөгөө: - Төлөвлөгөөний арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Стандартыг хэрэгжүүлэх ажлын хэсгийг томилж, төлөвлөгөөний төслийг боловсруулсан.	MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулж Төлөвлөгөөний арга хэмжээ хэрэгжсэн байна.	I-IV улирал	“Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: 1. “Эрүүл мэндийн ажилтанд тавих ерөнхий шаардлага” сэдэвт сургалтыг нийт ажилтнуудад 2024.08.22-ны өдөр зохион байгуулсан. 2. Үйлчлүүлэгчийг тав тухтай орчинд хүлээн авах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг сайжруулахаар хүлээн авах хэсгийн засварын ажлыг хийсэн. Хана, шалыг шаардлагад нийцсэн материалаар шинэчлэн засварлаж, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.   хуучин шинэ	100%

							 хуучин шинэ	
2.4.	Монгол улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчний жагсаалтад багтсан Хавдрын ген, хромосомын мутацийг	-	FISH шинжилгээний нэр төрлийн тоо, хамрагдсан хүний тоо	“Oncore pro” бүрэн автомат аппарат суурилуулагдаж FISH шинжилгээний стандарт ажиллагааны	Хавдрын ген, хромосомын мутацийг илрүүлэх, бай эмчилгээг тодорхойлох FISH шинжилгээний	I-IV улирал	3. Байгууллагын хаягийг стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэн, байршуулсан. 4. Төвийн өрөөнүүдийн хаягжилтийг шинэчилсэн. 5. Байгууллагын нийт ажилтнуудын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хугацаат үзлэгийг 2024.11.14-15-ны өдрүүдэд УНТЭ-ийн “Эрүүл мэндийг дэмжих төв”-тэй хамтран зохион байгуулсан.	95%

	илрүүлэх, бай эмчилгээг тодорхойлох FISH шинжилгээний аргыг нутагшуулна.			зааврыг боловсруулсан.	арга нэвтэрсэн байна.		1. БНХАУ-ын Бээжингийн Их Сургуулийн Хавдрын эмнэлэгт FISH шинжилгээний чиглэлээр 2 анатомийн эмгэг судлаач эмч, лабораторийн технологич нар молекул патологийн чиглэлээр 1 сарын сургалтад хамрагдсан. 2. 2024 оны урсгал төсвийн санхүүжилтээр эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодисны тендерээр HER2 проб, ажлын уусмал нийлүүлэгдсэн. 3. ЭСҮТ-ийн 2024 оны үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос урьдчилан хуваарилуулж, FISH шинжилгээнд ашиглагдах флюоросцент микроскоп, 5 нэр төрлийн проб, дагалдах ажлын уусмалын тендер зарлагдаж, гэрээ хийгдсэн.	
2.5.	Эмгэг судлалын тусламж, үйлчилгээнд цахим бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлнэ.	- 40 сая.төг	- Байгуулсан гэрээ - Боловсруулсан цахим бүртгэлийн тогтолцоонд нэвтэрсэн модуль	МИТПС хязгаарлагдмал хариуцлагатай компанитай хамтран ажиллахаар санал солилцсон.	-МИТПС ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байна. -Эмгэг судлалын тусламж, үйлчилгээнд цахим бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлсэн байна.	I-IV улирал	Эмгэг судлалын тусламж, үйлчилгээг цахим системд нэвтрүүлэх ажлын хүрээнд: 1. Цахим бүртгэлийн программ хөгжүүлэгч 6 байгууллагатай холбогдож, 3 байгууллагатай уулзалт хийсэн. 2. Дээрх компаниудаас Гүрэн Софт ХХК-ын “I-Hospital” цахим бүртгэлийн программ ашиглахаар 2024.11.10-ны өдөр гэрээ байгуулсан. 3. ЭСҮТ-ийн захирлын 2024 оны А/57 дугаар тушаалаар цахим бүртгэлийн программд холбох ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, гүйцэтгэгч байгууллагад холбогдох баримт бичгийг хүргүүлсэн. 4. Програмын хөгжүүлэлт 2024 онд багтаан хийгдэж, туршилтаар мөн оны 12.16-ны өдрөөс	90%

							ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангасан болно.	
Стратегийн зорилт 3. Манлайлагч эмгэг судлаач эмч, лабораторийн техникч нарыг хөгжүүлэх, Эмгэг судлалын чиглэлээр тэргүүлэгч төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллага болох								
3.1.	Улсын хэмжээнд эмгэг судлалын тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг нэмэгдүүлнэ.	Төрийн сангийн санхүүжилт болон хувийн зардал	Чадавхжуулах сургалт болон бэлтгэгдсэн эмч, мэргэжилтний тоо	2023-2025 оны "Анатомийн эмгэг судлал" үндсэн мэргэшлийн сургалтад 8 резидент эмч (Төв АНЭ-1, Ховдын Булган сум ЭМТ-1 Хувиараа-6) суралцаж байна.	- 2024 Анатомийн эмгэг судлал" үндсэн мэргэшлийн сургалтад 1 резидент төгссөн байна. - Анатомийн эмгэг судлал" үндсэн мэргэшлийн сургалтад шинээр резидент эмч нарыг элсүүлсэн байна.	I-IV улирал	Эмгэг судлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалт, мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж ажиллаж байна. • 2022-2024 оны "Анатомийн эмгэг судлал" үндсэн мэргэшлийн сургалтад 1 резидент эмч (Завхан АНЭ) суралцаж төгссөн. • 2023-2025 оны "Анатомийн эмгэг судлал" үндсэн мэргэшлийн сургалтын 2-р дамжаанд 7 резидент эмч суралцаж байна (Төв АНЭ-1, Ховдын Булган сум ЭМТ-1 Хувиараа-5). • 2024-2026 оны "Анатомийн эмгэг судлал" үндсэн мэргэшлийн сургалтад 6 резидент эмч шинээр элсэж, 1-р дамжаанд суралцаж байна. (Говь-Алтай НЭ, Дархан-Уул НЭ Хувиараа-4).	100%

				Эмгэг судлалын тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2023 онд 43 эмч, эмнэлгийн мэргэжилтэн үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамрагдсан.	- Аймаг, нийслэлийн анатомийн эмгэг судлаач эмч, эс судлаач нарыг төрөлжсөн мэргэшлийн ба мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.		• Төрөлжсөн мэргэшлийн 2024 оны хаврын элсэлтээр “Эсийн эмгэг судлал” төрөлжсөн мэргэшлийн сургалтад 1 эмгэг судлаач эмч хамрагдаж амжилттай төгссөн (Хэнтий АНЭ). • Лабораторийн техникчийн 2023-2024 оны элсэлтээр “Эд судлалын техникч” төрөлжсөн мэргэшлээр 4 лабораторийн техникч суралцаж төгссөн (Дундговь АНЭ, хувийн зардлаар-3). • 2024 оны намрын элсэлтээр “Эд судлалын техникч” төрөлжсөн мэргэшлээр 6 лабораторийн техникч суралцаж байна.	
3.2.	Эрдэм шинжилгээ, судалгаа хийх орчныг бий болгон гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	- 20,0 сая.төг Төсөл хөтөлбөр	- Эрдэм шинжилгээ, судалгааны хурал, - Байгуулсан гэрээний тоо - хурлын хөтөлбөр, илтгэлийн хураангуй хурлын эмхэтгэлийн тоо - олон улсын эрдэм шинжилгээний цахим хурлыг зохион байгуулсан хурлын тоо	- 2022 онд 1 магистрантын судалгааны арга аргачлалыг хэлэлцүүлсэн болно. - Жил бүр Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулан ажилладаг.	- Магистр, докторын сургалтад хамрагдаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтн и тоо, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн тоог нэмэгдүүлж, дэмжсэн байна. - Хамтарсан төсөл, хөтөлбөрийн тоог нэмэгдүүлсэн байна. - Олон улсын эрдэм шинжилгээний цахим бага хурлыг	I-IV улирал	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх хүрээнд: • ЭСҮТ нь эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх хүний нөөцийн баг бүрэлдэхүүнтэй болно. Тухайлбал: Докторын зэрэгтэй-2, докторын зэрэг горилхоор суралцаж буй-4, магистрын зэрэгтэй-10, магистрын зэрэг горилхоор суралцаж буй 8 эмч, эрүүл мэндийн ажилтнууд ажиллаж байна. • 2024 онд ЭСҮТ-ийн эмгэг судлаач эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд эрдэм шинжилгээний өгүүлэл 28, хурлын илтгэл 19 хэвлүүлсэн. • 2024.06.21-ний өдөр "Анатомийн эмгэг судлал алсын хараа-2024" олон улсын танхим, цахим хосолсон сургалтыг "Эмэгтэйчүүдийн эмгэг судлал ба эсийн эмгэг судлал" сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Төсөл хөтөлбөр: • Монгол Улсад хавдрын хяналтын чиглэлээр хийгдсэн Олон улсын хавдрын цогц үнэлгээний ЭМС-ын	100%

					зохион байгуулсан байна.	А/331 ба А/332 тоот албан бичгийн дагуу АТОМ хөтөлбөрийн хавдрын тусламж үйлчилгээний Impact хөндлөнгийн үнэлгээг орчуулж 3 удаа Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Хурлын санал, зөвлөмжийг тусган ЭМЯ-нд хүргүүлсэн. • Collage of American Pathologist (CAP)-ийн эмгэг судлалын шинжилгээний протоколыг Монгол улсад албан ёсоор орчуулж, нэвтрүүлэх зөвшөөрөл авсан. • CAP протоколыг Монгол Улсад практикт нэвтрүүлэх төслийн санал бэлтгэж ДЭМБ-д хүргүүлсэн. • LBC технологийг нэвтрүүлэх төслийн санал боловсруулсан. • “Artificial Intelligence Study of Pathological Images of Malignant Melanoma in whole sections” сэдэвт төслийг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Засгийн газрын шинжлэх ухааны төсөлд хүргүүлэхэд шаардлагатай материалуудыг бүрдүүлж, гадаадад илгээх бичиг баримтыг боловсруулж батлуулан хамтын гэрээ хийсэн. Хамтын ажиллагааны хүрээнд: - БНХАУ-ын “Бээжингийн их сургуулийн хавдрын эмнэлэгт”-тэй хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. - АШУҮИС-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. - Био-Анагаахын хүрээлэн хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. - Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.	
Стратегийн зорилт 4. Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх							

4.1.	Иргэдэд эмгэг судлалын тусламж үйлчилгээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэн ажиллана.	-	Цахим хуудсанд тавьсан мэдээллийн тоо, хандалтын тоо	Төвийн веб хуудсанд 2023 онд давхардсан тоогоор 232 мэдээллийг байршуулан ажилласан.	Эмгэг судлалын тусламж үйлчилгээний талаарх ойлголт иргэдийн дунд нэмэгдсэн байна.	I-IV улирал	Иргэдэд эмгэг судлалын тусламж, үйлчилгээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд: 1. “Үйлчлүүлэгч (Амьд сорьц)-ийн аюулгүй байдал сэдэв сургалтын хөтөлбөр боловсруулсан. 2. ЭМЯ-ны дэргэдэх Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөлөөр 2024.10.10-ны өдөр “Оношилгооны зорилгоор болон мэс заслаар тайрагдсан эмгэг эд, эсийн шинжилгээг эмгэг судлалын лабораторид тээвэрлэх тухай” сургалтын хөтөлбөрийг хэлэлцүүлэн батлуулсан. 3. ЭХЭМҮТ-ийн нийт эмч, ажилтнуудад “Үйлчлүүлэгч (Амьд сорьц)-ийн аюулгүй байдал сэдэвт 1 багц цагийн сургалтыг танхимын хэлбэрээр 2024.09.24-ний өдөр зохион байгуулсан. 4. Эмгэг судлалын лабораторийн нэг өдөр нээлттэй хаалганы өдөрлөгийг 2024.10.18-ны өдөр зохион байгуулсан. 5. Сондра эмнэлгийн нийт эмч, ажилтнуудад “Үйлчлүүлэгч (Амьд сорьц)-ийн аюулгүй байдал сэдэвт 1 багц цагийн сургалтыг 2024.12.04-ний өдөр танхимын хэлбэрээр зохион байгуулсан. 6. Эмгэг судлалын үндэсний төвийн https://www.facebook.com/emgegsudlal цахим хуудаст тус үндэсний төвд зохион байгуулагдаж буй бүхий л арга хэмжээ, ЭМЯ, СЭМҮТ, НЭМҮТөөс иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор нийтэлсэн шторк, нийтлэл, сурталчилгааг тухай бүр тогтмол хуваалцаж байршуулдаг. 2024.12.05-ны өдрөөс тус үндэсний төвийн https://www.facebook.com/emgegsudlal	100%
------	---	---	--	--	--	-------------	--	------

							la олон нийтийн мэдээллийн хуудсанд ЭМЯ-ны хэвлэл, мэдээллийн албанаас эрүүл мэндийн мэдээ мэдээлэл шууд нийтлэгддэг болсноор ЭМЯ-наас нийтэлж буй нийтлэл, Reel, видео шторкуудыг цаг алдалгүй олон нийтэд хүргэх боломжтой болсон.	
4.2.	Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлд давтан хамрагдана.	1 сая.төг	Итгэмжлэлийн гэрчилгээ	Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн “Магадлан итгэмжлэл олгох тухай” А/421 дүгээр тушаалаар 2 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн.	Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/554 тоот тушаалын хоёр дугаар хавсралтаар батлагдсан “Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагад магадлан шинжлэх шалгуураар үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу давтан магадлан итгэмжлэлд хамрагдсан байна.	I-IV улирал	- Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/554 дүгээр тушаалаар баталсан шалгуурыг үндэслэн Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын 2024 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн А/09 тоот тушаалаар магадлан итгэмжлэлд бэлтгэх үйл ажиллагааг эрчимжүүлэх багийг томилж, магадлан итгэмжлэлд бэлтгэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажиллаж магадлан итгэмжлэлд хамрагдахад шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн ажилласан. - Ажил сайжруулах төлөвлөгөөний биелэлтийг 09 дүгээр сарын 09-11-ний өдрүүдэд давтан үнэлэхэд магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн өөрийн үнэлгээ 95,1%-тай болсныг харгалзан, холбогдох материалыг хүргүүлсэн. - Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвийн Захиргаа, Санхүү, Удирдлагын Албаны даргын 2024.12.03-ны өдөр баталсан (№16 дугаартай) “Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудад магадлан итгэмжлэлийн үнэлгээ хийх шинжээчдийн багийн ажлын удирдамж” ёсоор Эмгэг судлалын үндэсний төвд 2024.12.11-ний	97%

							өдөр С.Буюмаа (ахлагч), С.Ариунболд, Д.Алтанцэцэг, С.Оюунгэрэл нарын шинжээчдийн багийн бүрэлдэхүүнтэйгээр ЭМСайдын 2019 оны А/554, 2020 оны А/179, 2020 оны А/180 дугаар тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу магадлан итгэмжлэлийн үнэлгээ хийж, зөвлөмж өгсөн.	
4.3.	Телепатологийн тусламж, үйлчилгээг ашиглан алсын зайн оношилгоог өргөжүүлнэ.	-	Зөвлөгөө авсан бүртгэл	Япон Улсын Хирошима их сургуультай хамтран Ховор болон төвөгтэй амьд сорьцын шинжилгээний 21 удаагийн тохиолдолд оношны зөвлөгөө авсан.	Телепатологийн тусламж, үйлчилгээг ашиглан алсын зайн оношилгоог гадаадын өндөр хөгжилтэй орны анатомийн эмгэг судлаач эмч нартай хамтран шуурхай үзүүлнэ.	I-IV улирал	1. Япон Улсын Токушима их сургуулийн эмгэг судлалын тасагтай Телепатологийн тусламжтайгаар 97 тохиолдол хэлэлцүүлсэн. 2. Япон Улсын Хирошима их сургуулийн Профессор К.Инай-аас Телепатологийн тусламжтайгаар 48 тохиолдол хэлэлцүүлсэн. 3. АНУ-ын New Orleans Хүүхдийн эмнэлгийн Профессор Mattew аас Телепатологийн тусламжтайгаар 8 тохиолдол хэлэлцүүлсэн. 4. АНУ-ын New Orleans Хүүхдийн эмнэлгийн Профессор Mattew “Хүүхдийн яс, зөөлөн эдийн эмгэг судлал” сэдвээр 5 удаагийн сургалт зохион байгуулсан. 5. ХБНГУ-ын Кауфберн Раунсбергийн Эмгэг судлалын институтын Профессор И.Альфер “Эмэгтэйчүүдийн эмгэг судлал”, “Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг судлал” чиглэлээр сургалт зохион байгуулсан 6. Япон Улсын Токушима ИС-ын Профессор Цунеяама “Элэгний архаг үрэвсэл” сэдэвт сургалт зохион байгуулсан	100%

4.5.	Олон улсын итгэмжлэгдсэн байгууллагын чанарын гадаад хяналтад хамруулна.	6.5 сая. төг Улсын төсөв	Чанарын үнэлгээний гэрчилгээ	Австралийн Эмгэг Анатомийн Рояль Коллежтой хамтран ажиллаж байна.	Австралийн Эмгэг Анатомийн Рояль Коллежийн Чанарын үнэлгээний хөтөлбөрийн анатомийн эмгэг судлалын оношилгооны "Gastrointestinal Diagnostic Modul" "Gynaecology Diagnostic Modul" хөтөлбөрт хамрагдаж, гэрчилгээ авсан байна.	III улирал	1. ДЭМБ-ийн санхүүжилтээр "Монгол Улс дах Хорт хавдрын тусламж, үйлчилгээний өнөөгийн нөхцөл, хөндлөнгийн үнэлгээ" зохион байгуулагдаж ЭСҮТ-өөс холбогдох тайлан мэдээллээр хангасан. 2. ДЭМБ-ийн санхүүжилтээр "Монгол Улс дах Хорт хавдрын тусламж, үйлчилгээний өнөөгийн нөхцөлийн хөндлөнгийн үнэлгээ"-ний тайлантай холбоотойгоор төлөвлөгөө боловсруулж ЭМЯ-нд хүргүүлсэн. 3. Австралийн Эмгэг Анатомийн Рояль Коллежийн чанарын үнэлгээний хөтөлбөрт хамрагдахаар Сетунари ХХК-тай гэрээ байгуулсан. энэхүү гэрээний дагуу "Gynaecology Diagnostic" онлайн хөтөлбөрт хамрагдаж, 100% буюу амжилттай үнэлэгдсэн. Мөн 2024 оны 7 дугаар сард "Gastrointestinal Diagnostic" онлайн хөтөлбөрт хамрагдаж, 80% буюу амжилттай үнэлэгдсэн.	100%
Стратегийн зорилт 5. Эмгэг судлалын тусламж үйлчилгээг чанартай хүргэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэвийн явуулах								
5.1.	Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, ЗГҮАХ-тэй уялдуулан Эрүүл мэндийг дэмжих санд төслийн санал хүргүүлнэ.	Төсөлд төсөв.	Боловсруулсан төсөл, тайлан	Дэмжих сангийн санхүүжилтээр 2019-2021 онд 5 төсөл хэрэгжүүлсэн.	Эмгэг судлалын үндэсний төвд хэрэгжүүлэх шинэ технологийг нэвтрүүлэхтэй холбоотой төслийг боловсруулан эрүүл мэндийг дэмжих санд хүргүүлсэн байна.	I-IV улирал	 • ДЭМБ-д CAP протокол орчуулгын төслийг байгууллагын төлөвлөгөө, стратеги, төсөлтэй холбоотой бусад	100%

							шаардлагатай санхүүгийн тооцоо гэх мэт бүрдлийн хамт англи хэл дээр орчуулж хүргүүлсэн. • Японы Токушима ИС, АШУҮИС, ХСҮТ-тэй хамтарсан “Хепатит вирусийн элэг эмгэгшүүлэх зарчим, механизмын илрүүлэх” сэдэвт судалгааны бүтээлийг ЭСҮТ-ийн Эрдмийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, протоколыг ЭМЯ-нд хүргүүлсэн. АШУҮИС-тай судалгааны хамтын ажиллагааны гэрээ хийсэн. ЭМЯ-ны Ёс зүйн хяналтын хороогоор хэлэлцүүлсэн. • Хавдрын ялган оношилгоонд ген, хромосомын мутацийг илрүүлж, хувь хүнд чиглэсэн бай эмчилгээний сонголтыг хийхэд молекул паталогийн оношилгоог нэвтрүүлэх нь сэдэвт төслийг боловсруулж ШУТСАН-ын инновацийн төслийн саналд хүргүүлсэн. • “Artificial Intelligence Study of Pathological Images of Malignant Melanoma in whole sections” сэдэвт төслийг ӨМӨЗО-ны Засгийн газрын хамтарсан төслийн шалгаруулалтад оролцсон. • Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх тэргүүлэх чиглэл (2025 он)-ийн санал болон тэргүүлэх чиглэлд нийцүүлсэн төсөл, арга хэмжээний саналыг 2024.11.08-ны өдрийн №378 болон 12.05-ны №413 дугаартай албан бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн. • ЭМЯ-наас Эрүүл мэндийг дэмжих сангаас төсөл нь санхүүжих 3,820,000,000₮ төсөвт өртөг бүхий “Монгол улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийг оношлох, эмчлэхэд шаардлагатай,	
--	--	--	--	--	--	--	---	--

							эмгэг судлалын лабораторийн багаж тоног, төхөөрөмж” (ЭМЯ/20240102125)-ийн тендерийг ЭМЯ-наас 2024.11.12-нд https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1731905815674 зарласан.	
5.2.	Барилга, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагааг хянаж шалгах төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангана.	-	Батлагдсан төлөвлөгөө, Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Барилга, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагааг ханган ажилласан.	Барилга, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагаа хангагдсан байна.	I-IV улирал	- Барилга, инженерийн байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хянаж шалгах 2024 оны төлөвлөгөөний дагуу улирал бүр үзлэг шалгалтыг хийж, засаж сайжруулах, авах арга хэмжээг тодорхойлж, түүний мөрөөр 2024 оны урсгал засварын батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулахад анхаарч ажилласан. - ЭХЭМҮТ-д объектод байрладаг байсан Хүүхдийн эмгэг судлалын тасаг ЭСҮТ-ийн төв байранд ирсэнтэй холбоотой лабораторийн урсгалыг стандартын дагуу зохион байгуулж, засвар үйлчилгээ хийсэн. - ЭСҮТ-ийн байр нь 1971 онд ашиглалтад орсон бөгөөд барилга байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангах, нэн шаардлагатай засвар үйлчилгээг хийсэн.	100%
5.3.	Санхүүгийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллах, Шилэн данс хуулийн хэрэгжилтийг хангана.	-	Шилэн данс, байгууллагын цахим хуудаст байршуулсан мэдээллийн тоо	Тухай бүр ил тод байдлыг ханган ажилладаг	Шилэн данс болон төвийн веб сайтаар ил тод байдлыг хангах зорилгоор оруулсан мэдээний тоо, хугацааг хуулийн хугацаанд оруулсан байна.	I-IV улирал	Санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж шилэн дансны портал систем болон байгууллагын шилэн данс, мэдээллийн самбарт жилийн төсвийн хуваарь, аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын зөвлөмж, гүйцэтгэлийн тайлан, цалингаас бусад таван сая төгрөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хоёр болон есдүгээр хавсралтын дагуу гаргаж мэдээллэсэн. 2024 оны эхний 11 сарын байдлаар дараах нэр төрлийн мэдээллийг давтамжаар мэдээллэсэн.	100%

						- Батлагдсан төсөв – 1 удаа - ХАА-ны төлөвлөгөө – 1 удаа - Төсвийн гүйцэтгэл – 11 удаа - Батлагдсан орон тоо – 11 удаа - Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ – 1 удаа - Дараа жилийн төсвийн төсөл – 1 удаа - ХАА-нд хийсэн аудитын тайлан, дүгнэлт – 11 удаа - Цалингаас бусад таван сая төгрөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ – 11 удаа - Цалингаас бусад таван сая төгрөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ – 11 удаа - Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт – 11 удаа - Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендер – 11 удаа - Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж – 11 удаа - Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа түүнтэй адилтгах – 11 удаа		
5.4.	Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2024 оны худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, Сангийн сайдын тушаалын дагуу тайлагнана.	-	Тендер зохион байгуулсан тоо, баримт бичиг, тайлан	Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөний дагуу 1 тендерийг цахим хэлбэрээр зохион байгуулах.	2024 онд Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулагдсан байна.	I-IV улирал	2024.10.31-ний өдрийн байдлаар ЭСҮТ нийт 3 тендер зарласан. 1. Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис худалдан авах тендер: - ЭСҮТ-ийн захирлын Үнэлгээний хороо 2024.01.11-ний өдрийн А/03 тушаалаар 5 гишүүнтэй, үүнээс 2 гишүүн нь төрийн бус байгууллага, хөндлөнгийн төлөөлөлтэй бүрэлдэхүүн томилсон. - Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг боловсруулж, ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу тендерийг нээлттэй, цахим хэлбэрээр зохион байгуулсан. Тендерийн зарлалыг Төрийн	100%

							худалдан авах ажиллагааны газрын www.tender.gov.mn цахим хуудас болон Өглөөний сонинд нийтэлж, нээлттэй, ил тод байрлуулж, хэрэглэгчдийг тэгш мэдээллээр хангаж ажиллаж байна. Нээлттэй тендер шалгаруулалтын журмыг баримтлан зарлалыг ажлын 15 хоног нийтэлсэн. - Тендерийг 4 багцтай зарласан бөгөөд 02.16; 04.03; 05.09; 06.07-нд нийт 4 удаа зарлаж амжилттай зохион байгуулсан. - Багц 1-спиртийг Мөнхийн тун ХХК, багц 2-химийн аюултай, хортой бодисийг Реактив ХХК, багц 3-эд, эсийн лабораторийн будаг урвалж, дагалдах хэрэгслүүд, багц 4-иммунохистохими, молекул генетикийн урвалж бодисыг Етемо ХХК нийлүүлэхээр гэрээ байгуулсан. 2. Лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах тендер: - ЭМЯ-аас 2024 оны урсгал төсөвт тодотгол хийж багаж тоног төхөөрөмжийн зардалд 150 сая төгрөг нэмэлтээр хуваарилсан. Үүнийг эмгэг судлалын лавлагаа лабораторит нэн шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахаар ЭСҮТ-ийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан. - Төвийн захиралын 2024.05.10-ны өдрийн “Үнэлгээний хороо байгуулах тухай” А/27 дугаар тушаалаар “Лабораторийн тоног төхөөрөмж” худалдан авах тендерийн үнэлгээний хороо 5 гишүүнтэй, үүнээс 2 гишүүн нь төрийн бус байгууллага, хөндлөнгийн төлөөлөлтэй бүрэлдэхүүн томилсон.	
--	--	--	--	--	--	--	---	--

							- Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг боловсруулж, ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу тендерийг нээлттэй, цахим хэлбэрээр зохион байгуулсан. Тендерийн зарлалыг Төрийн худалдан авах ажиллагааны газрын www.tender.gov.mn цахим хуудас болон Өглөөний сонинд нийтэлж, нээлттэй, ил тод байрлуулж, хэрэглэгчдийг тэгш мэдээллээр хангаж ажиллаж байна. Нээлттэй тендер шалгаруулалтын журмыг баримтлан зарлалыг ажлын 15 хоног нийтэлж, 2024.06.12-ны өдрийн 9.30 цагт нээлтийг хийсэн. Нийт 5 оролцогч компани материалаа ирүүлсэнийг үнэлгээний хороо Сангийн сайдын 2023.12.25-ны өдрийн А/255 дугаар тушаалаар батлагдсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын хянан үзэж, үнэлгээгээ хийсэн. Тендерийн үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны газрын www.tender.gov.mn цахим хуудаст хуулийн хугацаанд байршуулсан болно. - Хамгийн сайн үнэлэгдсэн оролцогч компани болох Сетунари ХХК-тай 2024.07.02-ны өдөр гэрээ байгуулсан. - Гэрээ хэрэгжүүлэх хугацаанд буюу 2024.08.26-ны өдөр нийлүүлэгч компани тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. 3. Лабораторийн тоног төхөөрөмж, урвалж бодис худалдан авах тендер: - ЭМЯ-аас 2024 оны үндсэн үйл ажиллагааны орлогоос 260 сая төгрөгийг хуваарилж молекул молекул патологийн шинжилгээ	
--	--	--	--	--	--	--	--	--

							хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж, урвалж бодис худалдан авахаар ЭСҮТ-ийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан. - Төвийн захиралын 2024.09.18-ны өдрийн “Үнэлгээний хороо байгуулах тухай” А/46 дугаар тушаалаар “Лабораторийн тоног төхөөрөмж, урвалж бодис” худалдан авах тендерийн үнэлгээний хороо 5 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь төрийн бус байгууллага, хөндлөнгийн төлөөлөлтэй бүрэлдэхүүн томилсон. - Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг боловсруулж, ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу тендерийг нээлттэй, цахим хэлбэрээр зохион байгуулсан. Тендерийн зарлалыг Төрийн худалдан авах ажиллагааны газрын www.tender.gov.mn цахим хуудаст нийтэлж, нээлттэй, ил тод байрлуулж, хэрэглэгчдийг тэгш мэдээллээр хангаж ажиллаж байна. Нээлттэй тендер шалгаруулалтын журмыг баримтлан зарлалыг ажлын 15 хоног нийтэлж, 2024.10.22-ны өдрийн 9.30 цагт нээлтийг хийсэн. Зөвхөн 1 оролцогч компани материалаа ирүүлсэнийг үнэлгээний хороо Сангийн сайдын 2023.12.25-ны өдрийн А/255 дугаар тушаалаар батлагдсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын хянан үзэж, үнэлгээгээ хийсэн. Тендерийн үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны газрын www.tender.gov.mn цахим	
--	--	--	--	--	--	--	--	--

							хуудаст хуулийн хугацаанд байршуулсан болно. - Шаардлагад нийцэж, хамгийн сайн үнэлэгдсэн оролцогч компани болох Етемо ХХК-тай 2024.11.08-ны өдөр гэрээ байгуулахаар бэлтгэж ажлыг хангасан.	
5.5.	Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг мөрдлөг болгон ажиллана.	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Жил бүр авлигын эсрэг төлөвлөгөөтэй ажилладаг.	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжсэн байна	I-IV улирал	- Байгууллагын удирдах албан тушаал эрхэлдэг 12 албан хаагчийн 2023 оны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд нь АТГ-т мэдүүлсэн. - Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг мөрдлөг болгон ажиллаж 2024 оны жилийн хугацаанд 10 ажилтны Хөрөнгө орлогын урлчилсан мэдүүлгийг АТГ-т хүргүүлэн хянуулж холбогдох албан тушаалд байгууллагын захирлын тушаалыг үндэслэн томилсон байна. - Авлигын эсрэг үйл ажиллагааг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулж Төвийн цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд байршуулан гарын авлага, зурагт хуудасаар албан хаагчид, иргэд, үйлчлүүлэгч нарт таниулан ажилласан.	100%
5.6.	Төвийн “Ёс зүйн төлөвлөгөө” боловсруулж хэрэгжүүлнэ.	1,0 сая Улсын төсөв	Батлагдсан ёс зүйн төлөвлөгөө, Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Жил бүр ёс зүйн зөвлөл төлөвлөгөөтэй ажилладаг.	Ёс зүйн төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн байна.	I-IV улирал	- Ёс зүйн салбар хорооны 2024 батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан. Нийт ажилтнуудыг соён гэгээрүүлэх зорилгоор 2024.05.27-нд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургалтыг Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартын дагуу “Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байранд нийтлэг мөрдөх хувцаслалтын хэм хэмжээ”,	100%

							“Үйлчлүүлэгч-төвтэй тусламж, үйлчилгээ”, “Байгууллагын соёл” сэдвүүдээр тус тус зохион байгуулсан. - Төрийн албаны зөвлөлөөс 2024.11.28-нд зохион байгуулсан "7:4:10" ээлжит сургалтад Монгол Улсын Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгсийн “Төрийн албан хаагчийн ёс зүй” (Ёс зүй ба бодлого, үйл ажиллагаа) сэдэвт семинар сургалтад тус үндэсний төвийн хамт олон хамрагдсан. . - Төрийн албаны зөвлөлийн ээлжит "7.4.10" сургалтад 2024.12.05-нд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын Төрийн албаны ангилал, зэрэглэл, цалин хөлс, нийгмийн баталгааны бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч О.Мягмарсүрэнгийн "Төрийн албан хаагчийн цалин хөлс (орон нутгийн нэмэгдэл)" сэдэвт семинар сургалтад тус үндэсний төвийн хамт олон хамрагдсан. - Төрийн албаны зөвлөлийн ээлжит "7:4:10" цахим сургалтын 2024.12.12-ны өдрийн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн, хууль зүйн ухааны доктор Г.Нарантуяагийн "Хүний эрхийн үндэсний комиссын чиг үүрэг, хүний хувийн мэдээллийг хамгаалахад анхаарах асуудал" сэдэвт семинар сургалтыг тус үндэсний төвийн https://www.facebook.com/emgegsu цахим хуудаст нийтлэв.	
5.7.	Бүсийн оношилгоо эмчилгээний төв,	-	Төлөвлөгөөг батлуулж, төлөвлөсөн арга	Эмгэг судлалын тусламж үйлчилгээний		Жилийн турш	Аймаг орон нутгийн эмгэг судлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор	100%

	Аймаг, сумын нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгүүдийн эмгэг судлаач эмч, эс судлаач нарын оношилгоонд чанарын гадаад хяналт, баталгаажилт /Quality control/ хийнэ.		хэмжээний хэрэгжилтийн хувь	дотоод хяналт, үнэлгээг хяналтын хуудсаар зохион байгуулсан.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.		(2024.10.24-ний №353 дугаартай албан бичгээр хөтөлбөрийг илгээв) дараах 5 чиглэлээр чанарын гадаад хяналт, баталгаажилтын ажлыг 2024 оны 11-р сард цахим хэлбэрээр зохион байгуулсан. Үүнд: 1. Эмгэг судлалын ерөнхий оношилгоо 2. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг судлалын оношилгоо 3. Эмэгтэйчүүдийн эмгэг судлалын оношилгоо 4. Умайн хүзүүний эсийн эмгэг судлал 5. Эмэгтэйчүүдийн бус эсийн эмгэг судлал 8 аймгийн нэгдсэн эмнэлэг дээрх 5 чиглэлээс сонгон давхардсан тоогоор 13 чиглэлээр хамрагдсан.	
Стратегийн зорилго 6. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх								
6.1.	ЗГҮАХ 2.1.1.3 Эрүүл мэндийн сайдын 2021 оны А760 тоот тушаалаар батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж, хэрэгжилтийг зохион байгуулна.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Эрүүл мэндийн сайдын тушаал 2021 онд батлагдсан.	Төлөвлөсөн арга хэмжээ 90-ээс дээш хувиар биелсэн байна.	Жилийн турш	-Төлөвлөгөөний биелэлтийг хавсаргав.	100%
